



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/187

Мяндулговь

“Ашид бьюлдинг” ХХК-тай нэмэлт
гэрээ байгуулах тухай


Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 34 дүгээр зүйлийн 34.2, 34.1.4 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж буй Эрүүл мэндийн төвийн их засвар (Дундговь, Адаацаг сум) ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Ашид бьюлдинг” ХХК-тай байгуулсан ЭМЯ/202002105-ны дугаартай 85,040,104 (наян таван сая дөчин мянга нэг зуун дөрөв) төгрөгийн гэрээний дүнг 12,738,147 (арван хоёр сая долоон зуун гучин найман мянга нэг зуун дөчин долоо) төгрөгөөр нэмэлт гэрээ байгуулсугай.

Хоёр. Нэмэлт батлагдсан зураг төсвийн дагуу Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн их засварын ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Ашид бьюлдинг” ХХК-ийн гүйцэтгэх захирал (О.Мөнхсаруул)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай нэмэлт гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Адаацаг сумын Засаг дарга (Ж.Батхөлөг) нарт ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010520